



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/333

Мандалговь

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар “Журам батлах тухай” тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчдад шагнал олгох журам”-ын 3 дугаар хэсгийн 3.3, 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 222 дугаар “Зарим аймгийн баяр наадмын хугацааг өөрчлөн тогтоох тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн баярын үйл ажиллагааг зохион байгуулахад идэвх санаачилгатай, шинэ санал санаачилга гаргаж ажилласан төрийн албан хаагчдад батлагдсан төсөвтөө багтаан мөнгөн урамшуулал олгохыг төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

2. Шагналд шаардагдах хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд тухайн байгууллагын батлагдсан төсөвт багтаан олгож, тайлагнахад хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111129